ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 03 өдөр Дугаар А/06 Хараат

Зарим албан хаагчдын ажлын цагийг
богтносгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 албан даалгаврыг үндэслэн ТУШААХ нь:

1.Шинэ коронавирусийн халдвар болон томуу, томуу төст өвчний үед болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа түр зогсоосонтой холбогдуулан Засаг даргын Тамгын газрын 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдыг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажлын цагийн хуваарийг 09.00-12.00, 14.00-17.00 цагийн хооронд мөрдөн богисгосон цагаар ажиллуулсугай.

2.Засаг даргын Тамгын газрын 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдын судалгааг хавсралтаар баталсугай.

3.Хавсралтад нэр дурдсан албан хаагчдын богиносгосон цагийг үндсэн цагаар тооцон цалинг бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Т.Хүдэрчулуун)-д даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Батгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.СОЛОНГО

482002025

Сумын Засаг даргын Тамгын газрын даргын
2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн
А/06 дугаар тушаалын хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН 0-5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН СУДАЛГАА

| № | Овог нэр | Албан тушаал | 0-1 нас | 2-3 нас | 4-5 нас | Нийт хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | З.Солонго | ЗДТГазрын дарга | | 1 | 1 | 2 |
| 2 | Ё.Мядагмаа | Санхүү албаны дарга | | | 1 | 1 |
| 3 | Г.Жаргалмаа | Багийн засаг дарга | 1 | | | 1 |
| 4 | Г.Эрдэнэтуяа | АБХЭрхлэгч | | 1 | 1 | 2 |
| 5 | З.Батсайхан | Нярав | | | 1 | 1 |
| 6 | З.Анхбаяр | Жолооч | | | 1 | 1 |
| Нийт хүүхдийн тоо | | | | | | 8 |